



ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН СОЁЛЫН ТӨВ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

[И-мэйл](#)

Аудитын багийн ахлагч Аудитор

Ц.Базарсад

Утас: 70272287

И-мэйл Bazaraatsend@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	6
• Залруулаагүй алдаа	7
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	7
• Аудитын санал дүгнэлт	7

Соёлын төвийн 2013 оны Санхүүгийн тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Соёлын төвийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Соёлын төвийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцогт сумын Соёлын төв тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. Аймгийн МХГазрын төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт 2014 оны 1-р сард хийгдсэн тул хяналт шалгалт аудитыг санхүүгийн тайлан, журналд түшиглэн анхан шатны баримтыг үзээгүй болно.
2. Харилцахын баримтын бүрдэлийг шалгахад анхан шатны баримтын бүрдэлт сайн байна. Харилцахын баримтанд сар бүрийн мөнгөн гүйлгээний журналыг хэвлэж хавсаргадаггүй улирлаар хэвлэж хавсаргаж хяналтын түвшингийн хуулга, гүйлгээ хийсэн баримтуудыг үдсэн байна. Цаашид харилцахын орлого зарлагын журналыг хэвлэж баримтандаа хавсаргаж байх талаар ня-бо С.Цэцэгсүрэнтэй ярилцсан.
3. Цалингийн зардлын бичилт нэг бүрийг цалингийн шатлал, зэрэглэл зэргийг нэг бүрчилэн шалгахад зөрчил илэрсэнгүй. Харин цалингийн сангаас бие засах газар бариулсан ажлын хөлсөнд 250,0 мянган төгрөгийг олгосон байна. Ажлын хөлснөөс татвар

НДШимтгэл тооцсон. Цалингийн сангаас үндсэн ажиллагсдын цалин хөлснөөс өөр зориулалт бусаар ажлын хөлс олгохгүй байх

4. Авлага өглөгийн тулган баталгаажуулалт хийхэд харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт тооцооны баримтаар жагсаалт үйлдэн баталгаажуулсан бөгөөд оны эхэнд татвараас 153.3 мянган төгрөгний авлагатай гарсан түүнийг 2013 оны төлбөрөөс хасаж тооцоон авлагыг барагдуулсан байна.
5. Тайлант онд урсгал засварын зардлаас үндсэн хөрөнгөнд 225,0 мянган төгрөгийн хашаа, төлбөр хураамжийн зардлаас 20,0 мянган төгрөгийн ном авч бүртгэлд тусгасан боловч мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардлаар тусгагдаагүй гаргасан зардалдаа тайлагнасан байна. Цаашид Төсвийн тухай хуулийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг баримталж ажиллах
6. Зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс зардлыг санхүүжүүлэхдээ бичилтийн алдаа гаргасан байна. Үүнд: Түлш халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд 150,7 мянган төгрөг, галч нарын нормын сүүний зардалд 107,9 мянган төгрөг, нормын бээлийн маск, насос авахад 349,5 мянган төгрөг, шатахууны зардалд 60,5 мянган төгрөгийн зардлыг гаргаж түлш халаалтын зардалд галч нарын нормын сүү, нормын бээлий маск, насосны үнэ болох 457,4 мянган төгрөгийг хааж бичсэн.
7. 2013 онд хийгдсэн эрсдлийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу дотоод хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан 3 чиглэлээр хяналт шалгалтыг явуулж тайланг илтгэх хуудсаар тайлагнаж биелэлтийг тооцон ажилласан нь

хяналт шалгалтын материалыг үзэхэд нотлогдож байна.

Ерөнхий менежерээс ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа
- Ерөнхий Аудитор 2014.03.11-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч С.Цэцэгсүрэн бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Төв Аймгийн Аудитын Газар

2014.03.11

Танилцуулга

1. Бид Аймгийн Баянцогт сумын соёлын төв 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Баянцогт сумын соёлын төвийн ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцогт сумын соёлын төв тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийхэд

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Аймгийн Баянцогт сумын соёлын төвийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн Баянцогт сумын соёлын төвийн захиралд тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Баянцогт сумын соёлын төвийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:
 1. **Санхүүгийн дотоод хяналтын талаар**
 - Байгууллагын дотоод хяналтыг 2013.05.12-ны өдрийн 01 тоот тушаалаар Соёлын төвийн дотоод хяналт шалгалтын нэгжийг шинэчлэн батласан байна. Дотоод хяналт шалгалтыг явуулах төлөвлөгөө гаргаж батлуулан хяналт шалгалтын нэгж 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
 - Дотоод хяналт шалгалтыг тоног төхөөрөмжийн ашиглалт, урлагийн хувцасны ашиглалт, нүүдлийн номын сангийн үйлчилгээ, номын сангийн техник төхөөрөмжийн хангамж ашиглалтын чиглэлээр хэрэгжилтийг шалгаж үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцон ажилласан байна.
 2. **Орлогын талаар**
 - 2013 оны батлагдсан төсвийн санхүүжилтыг 2012 оны гүйцэтгэлтэй харьцуулахад санхүүжилт 2103,8 мянган төгрөгөөр буюу өмнөх оноос 4,1 %-иар, төсөвт байгууллагын өөрийн орлого өмнөх оныхтой ижил 980,0 мянган төгрөгөөр төлөвлөгдсөн байна. Соёлын төвийн өөрийн орлого 2013 онд өөрийн орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

- 2013 онд санхүүжилт 52625,3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 980,0 мянган төгрөгөөр батлагдсан нь гүйцэтгэлээр санхүүжилт 52625,3 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 980,0 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

- Харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад төрийн сангийн, болон арилжааны банкны дансны үлдэгдэлгүй, санхүүжилт 52625,3 мянган төгрөг, өөрийн орлого 980,0 мянган төгрөг, зарлага 53605,3 мянган төгрөг, оны эцэст үлдэгдэлгүй, урьд оны үлдэгдэл 0,0, энэ оны үлдэгдэл 0,0, бүгд 0,0 мянган төгрөг төрийн сангийн баталгаа гарган бүрэн албажуулсан байна.
- Харилцахын баримтын бүрдэлийг шалгахад анхан шатны баримтын бүрдэлт сайн байна. Харилцахын баримтанд улирал бүрийн мөнгөн гүйлгээний журналыг хэвлэж хавсаргаж хяналтын түвшингийн хуулга, гүйлгээ хийсэн баримтуудыг үдсэн байна. Цаашид харилцахын орлого зарлагын журналыг сар бүрээр хэвлэж баримтандаа хавсаргаж байх талаар ня-бо С.Цэцэгсүрэнтэй ярилцсан.
- Нийгмийн даатгалын тооцоогоор өр, авлагагүй гарсан боловч НДХ-с ирүүлсэн тулган баталгаажуулалтын баримтаар 2013 оны жилийн эцсээр 247815,14 төгрөгийн авлага гарсан байна. Энэ нь НДХэлтсээс хийсэн хяналт шалгалтаар тавигдсан НДШимтгэлийн актанд алданги ногдуулсан төлбөр байна. Сар бүрийн мэдээг программ хангамжаар гаргаж байгааг хяналтын түвшингийн хуулгатай тулган шалгахад сарын мэдээгээ программ хангамжаар гаргаж хэвшсэн, сарын мэдээндээ байгууллагын өр, авлагыг тусгаж баталгаажуулсан байна.

4. Бараа материалын талаар

- Бараа материалын тодруулгын тайлангийн оны эхний үлдэгдэл 4772,0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 11546,1 мянган төгрөг, үнэ төлбөргүй ирсэн орлого 295,0 мянган төгрөг нийт 11841,2 мянган төгрөг нэмэгдэж, зарцуулалт 11287,5 мянган төгрөг, акталж устгасан 855,8 мянган төгрөг нийт 12143,3 мянган төгрөг хасагдаж эцсийн үлдэгдэл 4469,8 мянган төгрөг нь няравын тайлангийн үлдэгдэлтэй тохирч байна.
- Бараа материалын үлдэгдэл, санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэл, тодруулгын тайлангийн үлдэгдлийг тулган шалгахад зөрүү гараагүй.
- Бараа материалын тооллогыг цаг хугацаанд хуулийн дагуу хийж гүйцэтгэсэн байна. Бараа материалын үлдэгдэл няравын материалын үлдэгдэлтэй зөрүүгүй таарч байна

5. Үндсэн хөрөнгийн талаар

- ССАЖЯамнаас компьютер 500,0 төгрөг, ном 1146,1 мянган төгрөг, Иргэдийн хандиваар 1057,2 мянган төгрөгний тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 225,0 мянган төгрөгийн хашаа, 20,0 мянган төгрөгийн ном тус тус авч барилга байгууламж 225,0, тоног төхөөрөмж 1557,2, номын фонд 1166,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Сумын ИТХТ-ийн 2013.08.29-ны 66 тоот тогтоолоор 997,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 855,8 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө акталж устгасан байна.
- Хяналтын сорилоор “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Эд хөрөнгийн тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хариуцна”. 11 дүгээр зүйлийн 2-ын 1-д “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийнэ” гэсэн заалтыг биелүүлж тооллого хийж тооцоог бодон баталгаажуулсан байна.
- Элэгдлийг шалгахад элэгдлийг программаар бодуулсан байна.

6. Авлага, өглөгийн талаар

1. Авлага өглөгийн тулган баталгаажуулалт хийхэд харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт тооцооны баримтаар жагсаалт үйлдэн баталгаажуулсан оны эхний үлдэгдэл татварын 153.3 мянган төгрөгний авлагыг бүрэн барагдуулсан байна.
2. Өглөгийн тайлангаар өр төлбөргүй гарсан боловч НДХ-с ирүүлсэн тулган баталгаажуулалтын баримтаар 2013 оны жилийн эцсээр 247815,14 төгрөгийн авлага гарсан байна. Энэ нь НДХэлтсээс хийсэн хяналт шалгалтаар тавигдсан НДШимтгэлийн актанд алданги ногдуулсан төлбөр байна.
3. Журналыг ерөнхий дэвтрийн данстай тулгахад зөрүү гараагүй.

7. Цалингийн талаар

- 2013 онд 5 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар батлагдсанаас 4 орон тоотойгоор ажиллаж 1 орон тоо хэмнэж ажилласан бөгөөд мөн гэрээтийн 4 галчтай ажилласан байна.
- Ажилтнуудын цалинг ЗГ-аас гаргасан сүлжээнд нийцүүлэн тогтоосон байна. Цагийн бүртгэлийн товчоо, илүү цагийн тооцоололт, орон тоо, тушаал, цалингийн тооцоололтыг шалгахад хэмнэгдсэн зардал байхгүй байна.
- Цалингийн нэмэгдэл болон илүү цагийн олголтын байдлыг шалгахад гэрээт галч нарт цагийн тооцоог үндэслэн тооцоог хийсэн байна.
- Цалингийн зардал мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайлан зөрүүгүй тайлагнасан татвар, НДШ-д өр, авлагагүй гэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.
- Цалингийн программыг бүрэн ашигладаг, татвар, НДШ-ийн тайланг программаар гаргадаг.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 7 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Байгууллагын зардлын гүйцэтгэлийг бодитой бус тайлагнах нь төсвийн төлөвлөгөөг хийх, хянах, батлах, шинжилгээ судалгааны дүнд нөлөөлөх тул зардлыг үнэн зөв тайлагнаж байх
- Цалингийн сангаас үндсэн ажиллагсдын цалин хөлснөөс өөр зориулалт бусаар ажлын хөлс олгохгүй байх

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Баянцогт сумын соёлын төв авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

8.Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд соёлын төвийн удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

10. Аймгийн Аудитын газраас тус тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

ААГ

2014.03.11